



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/211

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Барилга хот байгуулалтын сайд болон аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар 2023 онд байгуулсан гэрээний 3 дугаар хавсралтаар баталсан салбарын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 1, 2, 3, 4 дүгээр заалт, Засгийн газрын баталсан 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.5.1.5, 2.5.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж байгаа болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа барилга, байгууламжийн зураг төслийн боловсруулалт, газар олголт, геодезийн хэмжилт, баримт бичгийн бүрдэл, угсралтын ажлын чанар, хуучин барилгуудын ашиглалт, инженерийн шугам сүлжээний техникийн болон эдэлгээний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хийгдэж байгаа удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг аймгийн хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах, дүнг 2023 оны 05 дугаар сард багтаан Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар дарга (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

4. Хяналт, шалгалтанд зарцуулах 6,035,000 (зургаан сая гучин таван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0392

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дүгээр
сарын 10-ны өдрийн 421 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: С.Нямдорж (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Гишүүд:

Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)

О.Төмөрчөдөр (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Д.Алтансувд (аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар
сарын 10 ны өдрийн 04 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



СУМДААР ЯВЖ ХИЙХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТӨСӨВ

| № | Хийгдэх ажил | Шаардагдах материал | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэг бүрийн зардал | Нийт зардал |
|-----|---|---------------------|--------------------|-------------|-------------------|-------------|
| 1 | 19 суманд байрлаж буй барилга, байгууламжуудын ашиглалт, угсралт, материалын чанар, гарал үүсэл, үйлвэрлэл, хот байгуулалт, цэвэр ус, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг, газар олголт, геодезийн хэмжилт, дулааны зуух, даралтад сав, инженерийн шугам сүлжээ, цахилгаан түгээх, дамжуулах, дэд станцуудад үзлэг, хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөх | Шатахуун | 500 | л | 2470 | 1 235,000 |
| | | Томилолт | 5 хүн* 15 хоног | хоног | 64,000 | 4 800,000 |
| ДҮН | | | | | | 6,035,000 |